

БАТЛАВ.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.БАЯРБАТ

ҮСХ-НЫ ДАРГЫН НЭРЭМЖИТ ҮЗЛЭГИЙГ
угтан хийх ажлын төлөвлөгөө

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах албан байгууллага
Хэлтсийн төвшинд		
1	DevInfo хэрэглээний программын орчинд статистикийн мэдээллийн аймгийн санд 2012 оны үзүүлэлтийг бүрэн хийж дуусгана.	Статистикийн хэлтэс
2	Хэлтсийн Web сайтыг тогтмол шинэчлэн статистикийн үйл ажиллагааг хэрэглэгч нарт үйлчилж сурталчлана.	Статистикийн хэлтэс
3	Шинээр сонгогдсон аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарыг шийдвэр гаргахад нь шаардлагатай эдийн засаг нийгмийн танилцуулга, гарын авлагаар хангана.	Статистикийн хэлтэс
4	2012-2016 оны Аймгийн ЗД-ын мөрийн хөтөлбөрт албан ёсны статистикийн үйл ажиллагааны чиглэлээр тусгагдах зорилтыг хэрэгжүүлж эхлэнэ	Статистикийн хэлтэс
5	Захиргааны статистик мэдээлэл эрхлэн гаргадаг ажилтнуудын уулзалт зохион байгуулах.	Статистикийн хэлтэс
6	Интернэтийн сүлжээ орсон сумдад улс, аймгийн албан ёсны статистикийн ажил-үйлчилгээг он лайн горимаар хэрэглэгч нар хүлээн авах гарын авлага бэлтгэж тархаана.	Статистикийн хэлтэс
7	Албан ёсны статистикийн үйл ажиллагаа болон статистикийн хууль тогтоомжийн талаар байгууллага аж ахуйн нэгжид сурталчилгаа хийнэ.	Статистикийн хэлтэс
8	2013 оны төлөвлөгөөт ажлын биелэлтийг бүрэн ханган биелүүлэх, хоцорч буй ажлуудыг чанарын өндөр түвшинд хэрэгжүүлж дуусгах	Статистикийн хэлтэс
9	2013 оны хагас, бүтэн жилийн мал тооллогын бэлтгэл ажлыг хангах чиглэлээр. А) 2013 оны хагас, бүтэн жилийн мал тооллогын үндсэн туслах маягтуудыг ҮСХ-ноос авчран, сум тус бүрээр хуваарилан хүргүүлнэ. Б) 2013 оны мал тооллогын талаар сумдад чиглэл өгөх, сургалт зохион байгуулах.	Статистикийн хэлтэс
10	Хүн амын өрхийн бүртгэлийн дэвтэр хөтлөж, программ дээр ажиллаж сурах талаар багийн Засаг дарга нарт заавар зөвлөгөө өгөх, иргэдийн сум хоорондын давхардлыг арилгах	Статистикийн хэлтэс Сумын ЗДТГ, Сум, багийн статистик хариуцсан ажилтнууд
11	Албан ёсны статистик мэдээний гаргалтанд хяналт мониторинг хийж ажиллах 5-7 сум	Статистикийн хэлтэс

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах албан байгууллага
12	Захиргааны статистик мэдээний гаргалтанд хяналт мониторинг хийж ажиллах 3-5 хэлтэс, газар	Статистикийн хэлтэс
13	Хөдөө аж ахуйн мэдээг хэрхэн гаргах талаар заавар зөвлөмж бэлтгэж, статистик хариуцсан мэргэжилтэн, газар тариалан, мал аж ахуй хариуцсан мэргэжилтэнүүдэд тарааж өгнө,	Статистикийн хэлтэс
14	Мэдээний үндэс болон нэгтгэлийн баталгаажуулалт, хадгалалтыг сайжруулах	Статистикийн хэлтэс
15	Хэлтсийн үйл ажиллагааг харуулсан самбар байрлуулан олон нийтэд байнга үйлчилгээ үзүүлэх	Статистикийн хэлтэс
16	Статистикийн хэлтсийн ажил үйлчилгээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр сурталчлан олон нийтэд хүргэх	Статистикийн хэлтэс
17	ҮСХ-ны даргын 2012 оны 12 сарын 5-ны 1/146 тоот тушаалаар батлагдсан, 2013 оны 1-р улирлаас эхлэн явагдах Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын дундаж цалингийн улирлын мэдээний маягт нөхөх зааврыг сонгогдсон аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодогч нарт заавар зөвлөгөө өгч сургалт хийх.	Статистикийн хэлтэс
18	Нөөц ашиглалтын хүснэгтийг жилээр байгуулахад шаардагдах үнийн судалгааг сонгогдсон аж ахуйн нэгж байгууллагийг хамруулан зохион байгуулж явуулан, ҮСХ-нд хүлээлгэн өгөх	Статистикийн хэлтэс
19	Улс, аймгийн зарим үзүүлэлтээр зэрэгцүүлсэн зиндаа, (2012 оноор) вэбэд хандах гарын авлага гаргаж удирдлага иргэдэд тарааж үйлчилнэ	Статистикийн хэлтэс
20	IPad-тай хэрэглэгчдэд EZ-stat, Monstat програмуудыг суулгаж, хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөө өгнө. Мөн www.1212.mn сайтыг хэлтэс агентлагуудын компьютерт суулгаж, хэрхэн ашиглах талаар аргагүйн зөвлөгөө өгч ажиллана.	Статистикийн хэлтэс
21	Хүн амын өрхийн бүртгэл, мал тооллогын программаас бүх үзүүлэлтүүдийн хүснэгтүүдийг гаргаж авах талаар гарын авлага бэлтгэж сум, багийн статистик хариуцсан ажилтан, интернэт хариуцсан мэргэжилтэнүүдэд өгч үйлчилнэ.	Статистикийн хэлтэс
Захиргааны статистик мэдээлэл эрхлэн гаргадаг хэлтэс, агентлагийн төвшинд		
1	ҮСХ-гоор батлуулан мөрдөж байгаа захиргааны статистик мэдээллийн хамралт, үнэн зөв байдлыг хангаж ажиллан, анхан шатны мэдээний үндсийг эрс сайжруулах	Холбогдох хэлтэс агентлаг
2	Тухайн салбарын захиргааны статистик мэдээллээр мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа хэрэглэх	Холбогдох хэлтэс агентлаг
3	Захиргааны статистик мэдээний гаргалтанд хяналт мониторинг хийж ажиллах 3-5 суманд	Холбогдох хэлтэс агентлаг
Сум, багийн төвшинд		

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах албан байгууллага
1	Сумын хэмжээнд бүртгэлтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар бизнес регистрийн санг хөтөлж, үйл ажиллагаа явуулж байгааг нь тухайн салбарын албан ёсны статистик мэдээлэлд байнга хамруулах	Сумын ЗДТГ, Сумын статистик хариуцсан ажилтан
2	Хүн ам өрхийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтөлж, ҮСХ-ноос хүргүүлсэн программ хангамжийг ашиглан шивж , үйл ажиллагаандаа ашиглаж хэвшин; хүн ам, өрхийн ердийн (төрөлт, нас баралт) болон механик хөдөлгөөнийг (шилжин ирсэн, явсан) тухай бүр тогтмол хийж, түүвэр судалгааны нэрсийн жагсаалтыг бэлтгэж гаргаж байх	Сумын ЗДТГ, Сум, багийн статистик хариуцсан ажилтнууд
3	Сум хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангууд, арилжааны банкны зээл болон бусад эх үүсвэрээр эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй иргэд, хувиар хөдөлмөр эрхлэгчдийг салбар бүрээр (аж үйлдвэр, ахуй үйлчилгээ, гуанз, цайны газар, ...) баг, сумын албан ёсны статистик мэдээлэлд бүрэн хамруулан үнэн, зөв гаргаж мэдээлэх	Сумын ЗДТГ, Сум, багийн статистик хариуцсан ажилтнууд
4	Төл бойжилт, том малын зүй бус хорогдол, тариалсан талбай, хураасан ургац, аж үйлдвэрийн зэрэг мэдээний анхан шатны үндсийг сайтар бүрдүүлэн, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байх.	Сум, багийн статистик хариуцсан ажилтнууд, Мал үржлийн алба
5	Үнийн мэдээний үндэслэлийг сайжруулан сумандаа хамгийн их борлуулалт хийдэг 3-5 дэлгүүрүүдийг тогтмол хамруулж дундажлан сар бүрийн өөрчлөлтийг бараа, үйлчилгээ тус бүрээр тусгаж мэдээлэх	Сумын статистик хариуцсан ажилтан
6	Сумын албан ёсны статистик мэдээллээр сар, улирал бүр нийгэм эдийн засгийн танилцуулга мэдээлэл бэлтгэж сумын удирдлага болон иргэдэд үйлчлэх	Сумын статистик хариуцсан ажилтан
7	Албан ёсны статистикийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжийг олон нийтэд танилцуулж, сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлэх	Сум, багийн статистик хариуцсан ажилтнууд
8	Сумын иргэдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор статистик мэдээлэлийн самбарыг ажиллуулж байнга тогтмол шинэчилж байх	Сум, багийн статистик хариуцсан ажилтнууд